



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/17

Чойр

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 дах хэсэг, Сангийн сайдын 228 дугаар тушаалын 9.5 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2020 онд хэрэгжсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц, үр дүнд хийх хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Н.Алтанцэцэг (Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга)

(Зөвшилцсөнөөр)

Нарийн бичгийн дарга: П.Наранмандах (Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд: Э.Хулан (Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн мэргэжилтэн)
Л.Одонтуяа (Санхүүгийн хяналт, аудитын албаны санхүүгийн хяналт, шинжилгээний улсын ахлах байцаагч)

(Зөвшилцсөнөөр)

Т.Эрдэнэбаяр (Мэргэжлийн хяналтын газрын Барилга, техник хяналтын улсын байцаагч)
(Зөвшилцсөнөөр)

2. Хяналт шинжилгээ, үнэлгээг холбогдох хууль, тогтоомжийн дагуу хийж гүйцэтгэн үр дүнг 2021 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсгийн дарга (Н.Алтанцэцэг)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Д.СОДНОМ

